

URTUU


ART CAMP 2020





URTUU
ART CAMP 2020

Khushig valley, Tuv province, August 2020



Editor in Chief — Dalkh–Ochir Yondonjunai
Batjil Bayar
Associate Editor: Ganbold Lundaa
Interviews: Ariunaa Jargalsaikhan
Computer Designer: Enkhnaran Enkhbold
Translation: Delgermaa Ganbat
Enkhchimeg Tsevegjav

Photo by: Bazarsad Lkhagva
Bat–Orgil Battulga
Chinbold Lkhagva
Munkhjargal Jargalsaikhan
Lemon Studio

Artist / Уран бүтээлчид

ARIUNTUYA Jambaldorj
BADAM Dashdondog
BAT–ERDENE Batchuluun
BATKHOLBOO Dugarsuren
BAZARSAD Lkhagva
BAYARTSETSEG (Godo)–Dashdondov
CHINBAT Bayanbat
CHINBOLD Lkhagva
CHINZORIG Renchin–Ochir
DALKH–OCHIR Yondonjunai
DAVAAJARGAL Tsaschikher
ENKHBOLD Togmidshiirev
ENKHJARGAL Ganbat
ENKHTUYA Byambasuren
GANBOLD Lundaa
LKHAGVASUREN Gombo–Ichin
MUNGUNTSETSEG Lkhagvasuren
MUNKH–ERDENE Munkhzorig
MUNKHJARGAL Jargalsaikhan
NARANDULAM Altantsetseg Densee
NARBAYASGALAN Ulambayar
NYAMDULAM Tsedevsuren
ODGARIG Turmunkh
PUREVSUREN Javkhlant
SAINBAYAN Iderchuluun
SOLONGO Tseekhuu
TUVSHINJARGAL Tsend–Ayush
BLUEBIRD ART CLIQUE

Жамбалдорж АРИУНТУЯА
Дашдондог БАДАМ
Батчулуун БАТ–ЭРДЭНЭ
Дугарсүрэн БАТХОЛБОО
Лхагва БАЗАРСАД
Дашдондов БАЯРЦЭЦЭГ (ГОДО)
Баянбат ЧИНБАТ
Лхагва ЧИНБОЛД
Рэнцэн–Очир ЧИНЗОРИГ
Ёндонжунай ДАЛХ–ОЧИР
Цасчихэр ДАВААЖАРГАЛ
Тогмидшийрэв ЭНХБОЛД
Ганбат ЭНХЖАРГАЛ
Бямбасүрэн ЭНХТҮЯА
Лундаа ГАНБОЛД
Гомбо–Ичин ЛХАГВАСҮРЭН
Лхагвасүрэн МӨНГӨНЦЭЦЭГ
Мөнхзориг МӨНХ–ЭРДЭНЭ
Жаргалсайхан МӨНХЖАРГАЛ
Дэнсээ НАРАНДУЛАМ
Уламбаяр НАРБАЯСГАЛАН
Цэдэвсүрэн НЯМДУЛАМ
Төрмөнх ОДГАРИГ
Жавхлант ПҮРЭВСҮРЭН
Идэрчулуун САЙНБАЯН
Цээхүү СОЛОНГО
Цэнд–Аюуш ТҮВШИНЖАРГАЛ
Хөх шувуу уран бүтээлийн нэгдэл

2020 хорио цээр буюу “ӨРТӨӨ” Арт Кэмп

Урлаг урлагийн төлөө байж урлаг хөгждөг гэж модернистуудын
100 гаруй жилийн өмнө тунхагласан үг одоо ч хүчтэй байна.
Энэ дэлхийд Өвчин визгүй зорчдог, мөн Хайр визгүй зорчдог.
\Монголын их яруу найрагч Б.Лхагвасүрэн, 2017 он\

Бүтээгч хүмүүн ямар ч цаг үед бүтээл туурвилаа хийсээр байдаг ажээ. Дайн дажин болсон ч мөн байгалийн гамшиг, тахал өвчний үед ч . . .
2020 он буюу COVID–19 нь хүн төрөлхтний түүхэнд хэдэн зуун жилээр тэмдэглэгдэх биз... Биднийг өөр замаар явах ёстойг анхааруулан сануулж буй мэт . . .
2020 онд бүхий л улс орон, хүмүүсийн бодсон төлөвлөсөн зүйлс өөрчлөгдсөн. Бид өмнө нь дуртай газруудаараа аялж, дуртай үйлчилгээ худалдаагаа хийж, дуртай соёл урлагийн ажиллагаанд оролцон цуглаж, наадан наргидаг бүх зүйлс хорионд орон зогссон . . .
Харин хөл хорионд олон сар болсон уран бүтээлчид “Хөх нар” төвөөс санаачлан хэрэгжүүлж ирсэн “Арт Кэмп” төслийг сэргээн M.A.R.S–тай хамтран ажилласнаар Монголын контемпорари урлагийн нэгэн шинэ эхлэл тавигдлаа . . .
2020 оны 3–р сарын сүүл хавьцаа УБ хотын жижигхэн урлангийнхаа хорионд байхдаа M.A.R.S төслийг санаачлагч, уран бүтээлч Гаваатай миний бие ярьж суухдаа M.A.R.S–д ӨРТӨӨ–лөн хүрэх санааг гарган “ӨРТӨӨ” Арт Кэмп–2020 төслийг эхлүүлэн ажилдаа орсон. Уг төсөл мэдээг “Хөх нар” төвөөс У.Нарбаясгалан уран бүтээлчдэд түгээн 8–р сар гэхэд 30 гаруй уран бүтээлчид ажиллахаар болсон бөгөөд энд “Хөх нар” төвийн уран бүтээлчид мөн зарим туршлагатай зураач, барималчдаас гадна “Цэнхэр шувуу” бүлгэмийн залуус нэгдсэн..

Бид удахгүй аялах газар руу өртөөлөн хүрэхээр бэлдэцгээв . . .

2020 taboo or ‘URTOO’ Art Camp

On this Earth, only the Disease travels without visa, except Love.
\B.Lkhagvasuren, grand poet of Mongolia, 2017\

A creative human keeps his creation in any period of time, despite the war, the natural disaster and even during the pandemic... The year 2020 or the COVID–19 will be recorded in the history of mankind for centuries onward... It seems to remind us to follow a different path...
The year 2020 has witnessed a total change in what the entire countries and the people planned for themselves. We used to travel to wherever we want, attain any service and trade in favor, and enjoy any entertainment, arts and cultural events and festivities, all of which were suddenly ceased due to lockdown and quarantine...
The artists who spent months in quarantine restored the ‘Art Camp’ project initiated and implemented by ‘Blue Sun’ society and collaborated with the M.A.R.S (Mongolian Artist Residence Studios), leading to a new start in Mongolian contemporary arts...
I, while having a talk with artist Gavaa, founder of M.A.R.S. during my stay in quarantine in my tiny studio in UB, initiated to reach the M.A.R.S. via ‘Urtoo’ (traditional courier station). So we started the ‘URTOO’ Art Camp–2020, which was informed by U.Narbayasgalan from the ‘Blue Sun’ to all the artists. By August, 2020, over 30 artists joined the project, including artists from the ‘Blue Sun’, prominent painters, sculptors and fellows from ‘Blue Bird’ community.

So we started preparing to the travel destination via courier stations...

M.A.R.S руу аялсан өдөр 2020–08–10, ХӨШИГИЙН ХӨНДИЙ
Энэ өдөр хориот хотоос гарч өөр гариг руу явах гэж байв. . . бүгд сэтгэл нь хөдөлж байлаа.
МАРС яг хаана байдаг билээ . . . Улаанбаатар хотоос 40 орчим км, Төв аймгийн Зуунмод хотоос 7 км зайд.
Дундговь, Өмнөговь руу явах замд Хөшигийн хөндий орчимд Улаанбаатар хотын гол бэлэгдэл Хэнтий нурууны үргэлжил болох БОГД ХАН уулын баруун өмнөдөд үргэлжлэх бэл тал хөндий, МАРС газар нутагт зүүн талаар нь жижиг шанд, баруун талаар нь Юмтын гол урсана.
Уран бүтээлчид маань зарим нь төөрч будлисан ч МАРС дээрээ энэ өдөртөө ирцгээж амжлаа.
МАРС маань ийм ойрхон байсан юм байна шүү дээ, Улаанбаатар хотоос 1 цаг яваад л очих газар.

August 10, 2020 – the day to travel to M.A.R.S or the KHUSHIG VALLEY
This day we are going to leave the quarantined city to another planet. We were all thrilled about the journey. Where is actually the M.A.R.S. located... At 40 km from Ulaanbaatar, 7km from Zuunmod, center of Tuv province...
Dundgobi... On the way to Umnugobi... in the Khushig Valley... a vast space, stretching in the southwest of the BOGD KHAN mountain, the symbol of Ulaanbaatar city and branch of Khentii mountain range...
The site of MARS has an asphalt river in the east and Yumt River in the west.
Some of the artists got lost on their way, yet we all could gather at the MARS.
MARS was so close indeed, only one hour away from Ulaanbaatar.

M.A.R.S дээр 2020–08–12, ХӨШИГИЙН ХӨНДИЙ
МАРС–ын урд тал, зүүнээс баруун тийш үргэлжлэх уудам газрыг ХӨШИГИЙН ХӨНДИЙ гэнэ.
Биднийг МАРС дээр очсоныг мэдсэн хориот хотын зарим урлаг судлаач болон урлаг сонирхогчид, зарим найз нөхөд маань ирэх сураг сонсогдов.
Бидэнд ердөө гуравхан хоног үлдсэн тул манайхан бүтээл хийх газар руугаа яаран явцгаав.

Бидний өдөр тутам харьцах газар орон зай Хөшигийн хөндийд уран бүтээлчдийн үйлдэл ид өрнөж эхлэхэд борооны үүлс өмнөөс манран гарах агшинтай зэрэгцэн зарим зочид ирж, бид ч бичлэгээ хийж, зургаа авч эхлэв.

August 12, 2020 – on the M.A.R.S, KHUSHIG VALLEY
The vast space stretching from east to west in the south of MARS is the KHUSHIG VALLEY.
We had a hearsay that some art researchers, amateurs and art lovers were to join us from the quarantined city.
We had only 3 days left, so we hurried to the site of artwork.

The space we commune daily is the Khushig valley. With the start of our creation of artworks, the rain clouds scudded from the south, where their performing, the creation and the artwork were ongoing in integrity. Some guests arrived, while we started our video and photo shootings.

M.A.R.S дээр 2020–08–11, ХӨШИГИЙН ХӨНДИЙ
Бидэнд зүүн урагш үргэлжлэх жижиг уулс бүхий тал хөндийг ширтэн харах таатай байв.
Өмнийн зүгийг чиглэх авто замаар машинууд хөврөн, доор хөндийд хүүхдийн тоглоомтой адил жижигхэн харагдана.
Энд нар, салхи мөн хөх тэнгэрт хөвөх үүлс, бас адуу, үхэр хонь бэлчинэ энэ бол МАРС. . .
Хотын хорио цээрээс салсан бидэнд өөр гариг бас манай гариг мөн.
Бид тодорхой хугацаагаар ирсэн ердөө 5 өдөр... одоо 4 хоног үлдсэн байна. . .
Уран бүтээлчдийн зарим нь МАРС дээр юу хийхээ төлөвлөж ирсэн бол зарим нь огт төлөвлөөгүй учир бүгд хийх юмандаа санаа зовон орчин тойронтойгоо танилцах хэрэгтэй байлаа. . .
Төлөвлөсөн ч төлөвлөөгүй ч бидний хийх ажил энэ газраас, энэ орон зайнаас хамаарна. . .
Бидэнд өгөгдөхүүн их байлаа. . . МАРС хэмээн жижиг гүвээний ард байх Юмтын шанд газрын орон зай дахь жижиг гүвээний дээрх өндөр газар болон баруун зүүн бэлүүдийг сонгов.
Зарим нь 1980 оны сүүлээр бүтээн байгуулсан усны далан хөндий дэх бетон цутгавар болон шонгуудыг сонгосон бол зарим нь МАРС–ын хүрээ Кэмпийн газар орчмыг сонголоо.

August 11, 2020 – on the M.A.R.S, KHUSHIG VALLEY
It was so pleasant to descry the valley and small mountains stretching southeastward. The vehicles heading to the south keep flowing, which appear as tiny as if toys amidst the vast valley.
Here, there are the sun, the wind, the clouds scudding in the sky, and the horses, sheep and cattle grazing on open pasture. This is the MARS...
For us, who were released from the quarantine, it's an alien planet and our actual planet.
We've arrived here for a certain period of time, particularly only for 5 days... and we have only 4 days.
Some of the artists arrived here with a definite plan what to create, while some arrived here without any certainty, thus all are worried about their arts to create. They need to get acquainted with the surrounding environment first...
Planned or not, our works will depend on the landscape formation where we are...
We have much given out there... Some chose the space at the Yumt shand (brook) in the north of MARS hillock, while some higher plateau and some the eastern and western slopes. Some chose the water dam and concrete blocks and poles constructed in late 1980's and some in the vicinity of the MARS camp...

M.A.R.S дээр 2020–08–13, ХӨШИГИЙН ХӨНДИЙ
Энэ өдөр нар шарсан сайхан өдөр, зочид хориот хотоос ирсээр тэдэнд үзүүлэх харуулах зүйлс нь уран бүтээлчдийн үйлдэл, урлаг...
Тэд хотын ямар нэг галерей, музей, театрт бус харин MAPC дээр, газар орон зайд л үзнэ, зарим уран бүтээлчдийн ажил 1–2 км газарт байх тул машинаар өртөөлөн үзэх хэрэг ч гарна...
Бүтээлчид маань бүтээлээ гүйцээн ажиллахын тулд 3 хоног зарим нь халуун наранд чулуу зөөж, зарим нь бүтээлээ байршуулах ажилд улайрсаар бидний арьс нар салхиар амьсгалан борлож эхлэв.
Бид MAPC дээр яах гэж ирлээ дээ бараг л үүний төлөө...

August 13, 2020 – on the M.A.R.S, KHUSHIG VALLEY
On this sunny day, guests keep coming from the quarantined city, and the objects to display were the performances of artists and their arts, which were accessible only on the MARS, but not in any of the gallery, museum or theater in the city. The artworks by some artists were at 1–2 km away, thus they needed to go by a car via courier station to visit the site and watch the artworks....
The artists were striving hard to finish their work within the next three days, some carrying stones in the heat of the sun and some installing their works on the site, all getting suntanned in the wind and the sun.
We have arrived to the MARS, almost only for this...

M.A.R.S дээр 2020–08–14, ХӨШИГИЙН ХӨНДИЙ
Ерөнхийдөө уран бүтээлчид маань үндсэн том газарт өрөг байршлын бүтээлээ гүйцээж байлаа...MAPC дээр цаг агаар тайван дулаан...
Зочид хүрэлцэн ирсээр... буцсаар ... Шөнөдөө бид Монгол асрын дотор холбосон хөгжим, зэмсгээ хэрэглэн саунд артаар хөглөгдөнө...Мөн рок хөгжмөөр амьсгалсаар, өдөр нь уртын дуу, үйлдлийн урлаг, MAPC кэмп–урланд яруу найраг, үйлдлийн урлаг бий болсоор л ...

August 14, 2020 – on the M.A.R.S,
Artists have almost completed their installation works over the main site... The weather is warm and serene on the MARS.
The guests have kept coming... returning... At nights, we were charged with sound art made from the music players and instruments inside Mongolian marquee... and the rock music, while during the day, the arts of long song, performance and poetry were emerging at the camp–Mars studio...

M.A.R.S дээр 2020–08–15, ХӨШИГИЙН ХӨНДИЙ
Үндсэндээ бид MAPC дээр ӨРТӨӨЛӨН ирсэн үүргээ гүйцэтгэжээ... Тэд сэтгэл хангалуун. Бидний энэ гаригаас буцах өдөр...хамгийн сүүлийн газарт үйлдлийн урлагаа үзэхээр үлдэн, харин зарим нь хориотой хот руугаа яаран буцав...тунаж үлдсэн хэсэг хүмүүс үйлдлийн урлагаа үзэн таашаал аван хонохоор шийдэв. Маргааш нь бороо асгарч, MAPC–аас хурдан хөдлөхийг сануулав...
Ямар ч байсан хориот хотдоо үзүүлэх юмтайгаа буцлаа...MAPC бидэнд ойрхон байдаг тул...дахин өртөөлөн ирнэ....

August 15, 2020 – on the M.A.R.S,
We have accomplished the mission on the MARS we arrived via URTOO. It's the day they return contently from this planet... Some stay to watch the last land art performance, some left back to the quarantined city in a hurry... Those, who remained to stay overnight, enjoyed the last strokes of performing arts at the camp. The following day, the rain poured, reminding us to leave the MARS as soon as possible...
Anyway we have returned back to the quarantined city, taking what we have created for watching. Once MARS is close to us... we will be back via URTOO again...

МАРС–ын газар ЮМТЫН шандыг өгссөн газар дахь орон зайн урлаг \ ЛАНД АРТ \

Энэ газар орон зайн бүтээлч Бадам, Түвшинжаргал, Пүрэвсүрэн, Солонго, Энхтуяа нарын сонголт. Мөн тэдэнд өгөгдсөн өгөгдөхүүн...тэдний сонголт...
Бүтээгч нар ямар нэг санаа олон боловсруулж байдаг ч хэзээ хаана хэрэгжүүлэхээ шийдэж чаддаггүй ... тэдэнд зүгээр ямар нэг юм хийх санаа байна...ийм боломж тэдэнд олдсон тэгээд л хийсэн.
Хэн үүнийг шийдсэн бэ?... ЮМТЫН шандын газар орон зай биш гэж үү... тэд бүтээлээ энэ газартай харилцан хааш хаашаа 10–20м, 100–200м талбайд газар орон зайн урлагийг бий болгосон...
Энэхүү газар нь нам дор, жижиг шандны зүүн болон баруун далан бэлүүдээс харж болох тул орон зайн бүтээлийн хэмжээгээ шийдсэн хэрэг...Тэд бүтэн 1–2 хоног чулуу зөөж, өрөгт зориулсан материалаа байршуулах гээд ихээхэн ажил болсон нь харагдана...Мөн энд агшин, үйлдлийн урлагууд ч бий болсон...


Үзэгч, зочид машинаар болон явган өртөөлөн очиж үзнэ... Тэд газар орон зайг өөрсдөө сонгосон уу эсвэл газар орон зай тэднийг сонгосон уу...сонирхолтой харилцаа...Хамгийн гол нь юу үзүүлэх гэснээ хийж чадсандаа сэтгэл ханалуун байгаа...Тэдний бүтээлийг холоос харах боломжтой... тэд үнэхээр газар орон зайтай харьцаж чаджээ...
Газар орон зай бол агуу том, бидэнд хэчнээн томоор хийх санаа байв ч холоос өчүүхэн жижиг харагдана...Харин хэлбэр орон зайг зөв сонгон санаагаа илэрхийлж чадсан бол тэр том... Үүнийг бүтээгч сэтгэлгээ л бий болгодог...Энэхүү бүтээлүүдийг харахын тулд хориот хотоос ирсэн зочид цуварсаар...

The LAND ART upward the MARS camp and YUMT shand

This site space is the given source... and their own choices of artists Badam, Tuvshinjargal, Purevsuren, Solongo and Enkh–tuya.
The creators always develop and process an idea in their mind, yet they are challenged where to embody their ideas... All what they have is the idea... They just crafted upon the chance that was given to them.
Who is the one that made the decision? Isn't it the space of YUMT shand... By communing with the land and its nature, they created land art pieces on the site, covering 10–20 or even 100–200 square meters...
The sizes of the artworks were chosen following the spaciousness of the site, which is visible from the eastern and western dams of the brook in the lowland and from the slopes... The artists had to carry stones for 1–2 days and it's obvious that they paid much effort to locate their materials for the installations... This site also hosted the momentary art and improvisations...

The audience and guests would visit and watch the artworks via courier stations on foot or by car. Did they select the landscape by themselves or the landscape chose them... curious relations... Most importantly, they are content to have achieved what they wanted to exhibit... Their works are visible from distance... They could truly commune with the land and space...
The landscape is boundless. No matter how immense we want to create, it'd look petite from distance... Yet, the idea is exposed through proper form and space, it's be immense... It's what the creative thinking generates... To watch these artworks, the guests from the quarantined city kept coming...





ТҮВШИНЖАРГАЛ Цэнд–Аюуш

TUVSHINJARGAL Tsend–Ayush

2020.08.12
12.8.2020

2020.08.12

12.8.2020













БАДАМ Дашдондог

BADAM Dashdondog

ЛУС ЭРГЭЖ ИРСЭН НЬ

RETURN OF THE ELEMENTAL

ПҮРЭВСҮРЭН Жавхлант

PUREVSUREN Javkhlant

ДӨРВӨН ЗҮГИЙН ОГТЛОЛЦОЛ

CROSSING OF FOUR DIRECTIONS









АЛТ УРСАВЧ УУЖ БОЛОХГҮЙ

RUNNING GOLD IS NONDRINKABLE



САЙНБАЯН Идэрчулуун

SAINBAYAN Iderchuluun





ОРШИХУЙ
EXISTENCE





СОЛОНГО Цээхүү

SOLONGO Tseekhuu

СОЛОНГОН ТӨӨРӨГДӨЛ

RAINBOW ILLUSION





СОЛОНГОН ТӨӨРӨГДӨЛ

RAINBOW ILLUSION











ЭНХТУЯА Бямбасүрэн

ENKHTUYA Byambasuren

САВ ЕРТӨНЦ

GAIA



САВ ЕРТӨНЦ

GAIA





МАРС–ын ДЭНЖ дагуух газар орон зайн урлаг /ЛАНД АРТ/

МАРС–ын дэнжийн баруун хойд бэлийг уран бүтээлч Ариунтуяа, Мөнх–Эрдэнэ нар сонгосон... Дэнжийн гол өндөрлөгт овоо босгосон газар. Энд медиа үйлдлийн уран бүтээлч Нарбаясгалан, Мөнхжаргал, Базраа, мөн саунд уран бүтээлч Даваажаргал нар өрөг үйлдлийн урлаг хийсэн. Энэ өдөр Хөшигийн хөндийд борооны үүлс манаран үйлдлийн агшинг тодотгоно... Нар зүүн хойд бэлд... Батхолбоогийн "ХИЙ" бүтээл орон зайгаа эзлэн харагдана...Бид юутай харилцаж чадаж байна вэ гэвэл энэ газар орчин, цаг, орон зай...
Энд сонирхолтой үзүүлбэрүүд явагдсан... Нарбаясгалан цагаан комбинезон өмсөж дэнжийн оройд зогсоно.... яг COVID–19–ын үед гаднаас Монголчуудаа хүлээн авч буй эмнэлгийн ажилтнуудтай адил харагдана...Харин Мөнхжаргал кэмп дотор байсан барилгын хуучин шилэн цонхон дээр янзага, чононы дүрст хайчилбар зураг наав. Энэ нь анимаци мэт харагдах авч, шилэнд нэвт харагдах тухайн газар орчин чулуу, өвс ургамал... түүний медиа арт ...удалгүй Нарбаясгалан хонины түүхий цувдай элэг бөөр, зүрх зэргийг идэж гарав... солиотой...
Тэд ийм үйлдэл хийхийг төлөвлөсөн бололтой...Энэхүү үйлдлийн цаана Хөшигийн хөндий дэхь борооны манантсан үүлс,тал хөндий дээр бөөгнөн хурсан бараан үүлс ...Энэ л агшин...Хөшигийн хөндий дэхь энэ өдрийн агшин...дахиж давтагдахгүй өдөр....энэ үед байсан цөөхөн үзэгчид азтай....Хойш зүглэн Ариунтуяагийн "Хөх уулзалт" өрөг бүтээлтэй харилцан Мөнх–Эрдэний өрөг үйлдлийн урлагийг олон үзэгчтэйгээр үзлээ...Түүний үйлдэл хийх үед хажуу бэлд хонь, ямаан сүрэг бэлчинэ...буцаж кэмп руу явах замд Батхолбоогийн "ХИЙ" нэртэй бүтээл юу ч ярихгүй орон зайгаа эзлэн харагдана...
Орой болжээ....Чинбатын кэмпийн хашаанд хийгдсэн "ХОТЫН ЗҮРХНИЙ БИЧЛЭГ" өрөг бүтээлийг ГОДО хашааны гадна зөөн гаргах агшин ....
Хөшигийн хөндийд манарсан борооны үүлс гэнэт ус асгалаа...нэг өдөр хэдхэн цагийн хооронд ийм олон үзүүлбэр үзнэ гэж үү...гайхалтай...
МАРС дээр болсон энэ цаг ....Энд болсон үйлдлийг зарим нь үзсэн зарим нь үзээгүй...Урлагийг хэн хийгээд байна вэ?....Зөвхөн энэ өдөр, цаг орон зайтай харилцсан... агшны урлаг.

The LAND ART along the hills of MARS

The northwestern slope of the MARS was chosen by the artists Ariuntuya and Munkh–Erdene... The peak of the hill with an Ovoo cairn is where artists Narbayasgalan, Munkhjargal and Bazraa displayed their media performances along with the installation art piece by a sound artist Davaajargal accompanied by rain clouds above Khushi Valley that highlighted the moments of his performance... In the northeastern slope, the artwork titled 'AIR' by Batkholboo is seen in its space... What we commune with is this land, the time and the space...
Interesting performances have taken place on this site... Narbayasgalan in white coverall stands on the peak of the hill... Appearing as if medical workers receiving Mongolians from abroad during COVID–19... Munkhjargal, was spotted like an animation character, applying paper cuts of fawn and wolf on an old glass window that was at the camp, yet the landscape, stones and grass seen reflected on the glass... his media art... soon Narbayasgalan was seen eating raw offal, liver, kidney and heart... insane...
They seem to have planned to perform this... Beyond these performances, the rain clouds and the hazy valley... the dark clouds hovering over us... this moment... this moment of this day at Khushig valley... an unrepeatable day... Fortunate are the few guests who attended this performance...
Heading to the north, we interfaced the installation of 'Blue Meeting' by Ariuntuya and the installation artwork by Munkh–Erdene... During his performance, flocks of sheep and goats graze on the near slope. On the way back to the camp, the artwork titled 'AIR' by Batkholboo stands muted in silence, taking its space...
It's already evening... The moment of GODOT moving the installation titled 'City cardiogram' launched just outside of the camp... The clouds that were hovering over the valley suddenly poured rain... So many performances within a few hours in one day... stunning... this moment occurred on the MARS... some have seen these acts occurred here, while some not... Who is making the art... the momentary art communing with this day... time and space.





МӨНХ–ЭРДЭНЭ Мөнхзориг

MUNKH–ERDENE Munkhzorig

БАЙРШИЛ

LOCATION

БАЙРШИЛ

LOCATION












БАТХОЛБОО Дугарсүрэн

BATKHOLBOO Dugarsuren

Хий

GAS





АРИУНТУЯА Жамбалдорж
ARIUNTUYA Jambaldorj





ЦЭНХЭР УУЛЗАЛТ

BLUE MEETING


ЭНД БАЙСАН
WAS HERE



НАРБАЯСГАЛАН Уламбаяр

NARBAYASGALAN Ulambayar

Дахин Эхлэх

RESTART









ЭНХБОЛД Тогмидшийрэв

ENKHBOLD Togmidshiirev

ХӨХ СЭРЭХҮЙ

AWAKENING





ЭНХЖАРГАЛ Ганбат

ENKHJARGAL Ganbat

АТМАН 2

ATAMAN 2

ATMAH 2

ATAMAN 2







МӨНГӨНЦЭЦЭГ Лхагвасүрэн

MUNGUNTSETSEG Lkhagvasuren

ӨЧИГДӨР

YESTERDAY



МӨНХЖАРГАЛ Жаргалсайхан

MUNKHJARGAL Jargalsaikhan







УЛГЭР БИЕЛЭХ ЦАГТ

WHEN THE FAIRYTALE COMES TRUE










ХАЙРЦАГ
CUBE


KIA MOTORS





БАЗАРСАД Лхагва

BAZARSAD Lkhagva

ДУГУЙГААС ДӨРВӨЛЖИН РҮҮ

FROM CIRCLE TO CUBE





МАРС буюу кэмпийн хүрээнээс хол болон кэмп дотор хийгдсэн урлаг

МАРС–ын дэнжээс 3 км орчим машинаар өртөөлөн очих газар уран бүтээлч Гаваа “ОВОО” бүтээлээ хийж үзүүллээ...Нэгэн жижиг довыг сонгожээ... Түүний машинд суусан биднийг тэрхүү довыг тойруулан эргэлдэн давхив...Баруун гар талд суусан хүмүүс довны оройг харан эргэлдэж, зүүн гар талд суусан хүмүүс гадагш эргэн тойрноо харан эргэлдэнэ....эргэлдсээр л байв... толгойг минь эргүүлэх гэж үү?...Харин машинаас буун түүний машиныг дахин эргэлдэн давхихийг гаднаас харахад тийм ч сонирхолтой бус аж...Тэрээр өөрийнхөө овоог бий болгож.... машинаар эргэлдүүлэн жижиг довыг тойрсон тойрог зам нь тэрхүү орон зайд тодрон үлдэж хоцров...Энэ сонирхолтой ул мөр...
МАРС–ын энгэр дэхь кэмпийн хашаан дотор Чинзориг жижиг газар өвсний толгойнуудад амьд мэт харагдах нүдний зургуудыг байршуулсан харагдана... Түүнийг хэвтээ өнцгөөс харах боломжтой... Жижиг зүйлсийг ойроос шагайн харахад тод томруун бүтэн болж харагдана... Бат–Эрдэнэний бүтээл бас ийм жижиг, тэрээр жижиг зэс ялтас, зэс утсаар баримал хийсэн. Түүний бүтээлийг газар хэвтэн цаад орон зайтай нь харах хэрэгтэй...Бүтээгчийн өчүүхэн зүйлс болоод хэдэн зуун метр бүтээл нь газар орон зайтай харилцах тэр мөчийг бэлэглэнэ..Сонирхолтой бус гэж үү?...
Мөн Баярцэцэг\Годо\ –ийн томоор цаасан дээр хэвлэсэн яруу найргууд борооны усанд норон Урлангийн модон байшингийн гадна харагдана...Тэрээр бусдад садаа болохгүй чимээгүй аж...
Тодгариг хэмээх нэгэн залуу яруу найрагч, уран бүтээлч Гаваагийн урлан дотроос цонхоор гадагш ажиглан суух хүмүүст зориулан яруу найргаа сонсгоно...
Марс дээрх хугацаа дуусах дөхөж байх үед уран бүтээлч Энхболдын эхнэр хүүхдүүдийн хамт ирэв ээ... Тэр хаа ч явсан өөрийн гараар бүтээсэн гэртэйгээ явдаг... Энэхүү гэр нь уньгүй, зөвхөн матмал ханаар бүтээгдсэн ...Энэ гэр Скандинавын орнуудын галерей, соёлын төв, Англий Манчестр, Солонгосын Пусан, Хятадын Шанхай, тэр бүү хэл Венецийн олон улсын биеналд оролцсон...
Тэд нар хэвийн үдэш болж байхад МАРС–ыг зорин хориот хотоос эхнэр Мөнгөнцэцэг хүүхдүүдийн хамт иржээ... Тэрээр машинаасаа буунгуут өөрийн гэрээ угсран гэрээ дээш харуулан эргүүлэн өргөсөн нь дээшээ харсан аяга мэт харагдана...МАРС–ын дэнж өөд өгссөөр дээр гаран буулаа.... Аргалын утаа суунаглан шингэх нарны туяанд гайхалтай харагдана.... Тэрээр том аягаар айраг ууж гарлаа...Бид юу үзэв ээ?...Бас л энэ агшин, газар, цаг, орон зай...
Тэрээр гэрээ миний жижиг гэрийн хажууд барин, гэртээ зориулж хийсэн жижигхэн зуухаа галлан хоол, цай хийж эхлэв...Кэмп–д бид газар зуух ашиглан мөн том тогоонд хоол хийдэг ч... хажууд бүр амьд дотно... Ийм үйлдэл маш сонирхолтой...
Тийм жижиг гэрт дөрвөн ам бүлээрээ, тэгээд бүр бүх зүйлстэйгээ явах... Тэдний Поробокс машинд эд бүгд багтана...Тэрээр “Хөх нар”–ын уран бүтээлч болсон цагаас Монголын орчин үеийн урлагийг төлөөлөн гадаадын кураторуудын анхааралд байдаг хүн....
Энхболд энэхүү жижиг гэртээ гэр бүл эхнэр хүүхдүүдийн хамт амьдарч, гал түлж, хоол цай хийн, нутгийн айргаар дайлах бүхий л үйлдлээрээ бидэнд урлаг хийн үзүүлж буй мэт санагдав...
МАРС–аас хөдлөх өдөр эхлэлээ... Хориот хот руугаа яаран ихэнх нь үд дунд гэхэд явцгаасан байв...
Үйлдлийн урлаг хийхээр төлөвлөн ирсэн Мөнгөнцэцэг үйлдэлдээ зориулсан нимгэн цагаан торгон дээлээ оёж дуусгалаа. Тэрээр кэмпийн хойгуур явах зам дэнж өөд өгсөх газрыг сонгожээ.... Өөрийн хүрган дотортой дээлийг бургасан модоор тэлүүлэн замын голд суурилуулжээ..... 3–4 м–ийн зайд жижиг төмпөнд зуурсан гипсэнд нүцгэн хөлөө дүрэн тэлэн босгосон дээл дээрээ очин алдлан зогсоно...Энэхүү үйлдэл олонтой давтагдан тэлсэн дээл төмпөн хоёрын хооронд эмэгтэйн цагаан гипсэн мөрүүд бий болсоор л ...Харин төмпөн доторх түүний хөлний хэв баримал болон үлдэв...
Иймэрхүү үйлдлийг бид ямар нэгэн театр, галерей, музейд ч харахгүй...
МАРС дээр өртөөлөн 4–хөн өдөрт ийм олон үйлдэл хийсэн гэхэд санаанд багтамгүй мэт санагдав...
Бид ийм их эрч хүчийг хаанаас олоод байна вэ?
Ер нь бүтээлч хүмүүн ямар нэгэн санаа сэдэл олж түүнийгээ хийж, үйлдэхийг зорьж, төлөвлөж, төсөөлж байдаг ч тухайн цаг орон зайнаас хамаарч санаатай болон санаандгүй үйлдэл хийдэг... Тэр нь угаасаа бидэнд зүгээр л оршиж байсан зүйл аж...Үүнийг л бид урлаг гэж хэлэх дуртай...

Arts created within and away from the MARS camp

Three kilometers away from the MARS hill, we drove to a site, where artist Gavaa exhibited us his artwork 'OVOO' (Cairn)... He chose a small hillock... All of us seated in his car, he drove around the hillock... Those, who seated in the right side of his car encircled the hillock, watching the top of hillock, while those in the left side watching outward the surroundings... He kept encircling... To drive us dizzy... Taking off the car and watching his encircling the Ovoo by car wasn't much of interest... He created his Ovoo... A circular path of his car drive around the hillock was left in that space... A curious trace...

Chinzorig, inside the camp in the lap of MARS, placed images of life–like eyes at the tips of tiny grasses... It's visible only if prostrate... Small objects look larger and com–plete from close–up... The works by Bat–Erdene are sculptures of the same miniature size, which he made from tiny copper chips and copper wires. His work 'Khugshigt Valley', which we watch with the space beyond by lying on the ground... Isn't it interesting that the tiny and massive works, covering square of hundreds of meters, communi–cating with the space...

The poems by Bayartsetseg /Godot/ printed on papers in larger scale are drenched in the rain outside the wooden house of the studio... She keeps silent without disturbing other...

A young poet named Todgarig recites his poems for those, who sit watching outward from the studio of artist Gavaa...

As our stay on the Mars was coming to the end, artist Enkhbold arrived with his wife and children... Wherever he goes, he carries the ger he himself made by hand... this ger was made only of curved lattice walls without any poles... and was exhibited in his performances and joint exhibitions at galleries in Scandinavian countries, Manchester in Great Britain, Pusan in Korea, Shanghai in China and even international biennials in Venice, Italy...

He arrived with his wife Munguntsetseg and his children from the quarantined at the MARS in the evening... As soon as he took off his car, he assembled his ger and lifted it inverted in the air, which looked like a bowl... He kept ascending the hillock of MARS and reached the top... The smoke of burnt dung raises up in the light of setting sun, creating an eye–pleasing sight... He started then drinking airag in a large bowl... What we have watched... Again this moment, place, time and space...

He erected his ger next to my small ger... made fire inside the small stove specifically desgined for his ger and started cooking dinner... Although we cook meal on a gas stove or in a large cauldron in the camp... it's more lively and close when next to us... such acts are so interesting... His family of four with everything they need fit inside such a small ger... All of them fit inside his Probox van... Since his membership as an artist of the 'Blue Sun' center, he has represented Mongolian contemporary arts and has stayed in the center of attention of foreign curators...

Enkhbold, his small ger, his wife and children... make fire, make tea and cook meal and offer local airag from their birthplace, all of which seem to be their art that they all perform together...

The day to leave the Mars has come... Most of them had left already by noon hurrying back to the quarantined city...

Munguntsetseg, who had planned a performing art, finished sewing a white silk deel for her performance and chose the pat in the north of the camp, ascending upward the hill... where she placed her lambskin deel stretched with wooden pole in the middle of the road... She steps into the gypsum inside a bowl and then walks to the pole with her stretched deel, some 3–4 meters away, and stands with her arms stretched... After repeating this acts numerous times, white gypsum footprints were made between the bowl and the deel one after another... while the imprint of her feet was left, turning into a sculpture...

We haven't seen any such acts in any theater, museum or gallery...

It seems to be inconceivable that so many performances have occurred within four days via Urtoo at the MARS...

Where do we acquire so much energy from...

A creative person always has an idea and plans and visualizes to realize it, yet acts as if intentional or accidental depending on the given time and space... That's actually what has already existed within us... That's what we love to call as an art...

ЧИНЗОРИГ Ренчин–Очир
CHINZORIG Renchin–Ochir

МЭЛМИЙ ЦЭЦЭГС

THE EYE





МЭЛМИЙ ЦЭЦЭГС

THE EYE





ЧИНБАТ Баянбат

CHINBAT Bayanbat

НҮҮДЭЛ–ЗҮРХНИЙ БИЧЛЭГ

MIGRATION–CARDIOGRAM









БАТ–ЭРДЭНЭ Батчулуун

BAT–ERDENE Batchuluun



ШИНГЭ

SATURATE

ДАЛХ–ОЧИР Ёндонжунай
DALKH–OCHIR Yondonjunai







МОД


| Өглөөний магтуу |

Онгон улирлын гэгээ
Онгон улирлын гэгээ
ариун нандин зүйрлэмгүй
нандин ариун зүйрлэшгүй
хаврын эгшиг зуны үдэш
хаврын эгшигт зуны үдэш
тэнгэр нисэх хараацайн сүрэг
тэнгэрт нисэх харааацайн сүрэгт
зүүрмэглэх байгалийн нойрмог харц
зүүрмэглэх байгалийн нойрмог харцнаас
зүүдний гүндээ бодлогошронгуй амирлан
зүүдний гүнээс бодлогошронгуй амирлаад
цэв цэнхэрээр туяарах хязгааргүйн мэлмий
цэв цэнхэрээр туяарагч хязгааргүй мэлмий
зүүдний гүнд бодлогошронгуй амирлагч
Зүүрмэглэх байгалийн нойрмог харц
цагаан тэнгэрүүд болзоонд яарч
цав цагаан тэнгэр болоод
.....
тунгалаг усны шидэт мөнгөн дусал
тунгалаг ариун усны шидэт мөнгөн дусал
хонхон цэцэг жингэнэн цэцэгт бороо шиврээд
хонхон цэцэгс жингэнэн цэцгэн бороо шивэрч
далайн салхидаас нахиалсан тэмдэгт моддын
далайн салхинаас нахиалсан тэмдэгт модны
үүрийн гэгээ цэгээн гэрэлтэгч цэнгэг агаар
үүрийн цэгээн гэгээ гэтэлгэгч цэнгэг агаарт
үүрд нойрссон хоёр төгсгөл зурвас ирмэгт
үүрд нойрссон хоёр төгсгөл зурвас ирмэг
болор шүүдэр нөмөрсөн мөчир дээрээс
цоорын аялгуу талын зүүднээсээ өндийн
цоорын аялгуу дуниар тал зүүднээс өндийж
домогт зуны салхи нойрноос намуухан сэрээд
домогт зуны салхин нойрноосоо намуухан сэрэв

БАЯРЦЭЦЭГ (Годо) Дашдондов

BAYARTSETSEG (Godo) Dashdondov

ЭЗГҮЙ
суурин тосгодын аялага
элж мөлж буй хэлмэрүүд ..
өмнөөс цэлийх нарыг
угтан үдэгч цонхнууд
эзгүй сохор байшингууд
өөр хоорондоо сүлжилдэх
мухир тахир гудамжууд
биесээ шүргэм завьнууд
золбин нохой хар тамхичид
хуримын толгойн чимэг
нойрмог хий үзэгдлүүд
амилсан торон хөшгүүд
хардах сэрдэх мэдрэмжүүд
ойлгомжгүй төөрөг мөрөөдлүүд
харанхуйд бүгсэн гутралууд
халуун хүйтэн өнгүүд
бүхнийг бүчин тэвэрчээ
чиний амьсгал өнөөдөр л
сэтгэлээс үүрд арчигдвал
эзгүй хоосноос ангижрах уу
эртний дууг намуухнаар
хайнгадуухан аялах Түрэг эр ....



ГАНБОЛД Лундаа

GANBOLD Lundaa

TAILBARGUI

UNTITLED





TAILBARGUI

UNTITLED









ОДГАРИГ Төрмөнх

ODGARIG Turmunkh


3.30 AM


Эхлээд нэгийг хэрэглэдэг байсан. Өдөрт нэг цаас. Өглөө сэрээд орой хүртэл. Энэ хэвээр 4 хоносон. 5 дэх өдрөөс өдөрт 3 ширхэг. Сарын дараа гэхэд өдөрт 27 ширхэг.
Тэр хаяа гал тогооны өрөөнөөс хутга авч гартаа барьдаг. Хутга эхийнх нь тухай бодуулдаг. Тэгээд эргүүлэн хийнэ. Дотогш нь. Энэ үед цаг хугацаа наалдамхай болдог. Секундын зүү гурван секунд нэг шилжинэ.
Шалнаас ширээний хөлрүү шилжихэд өрөө дургүй, хөдөлж ядна. Унтах хэрэгтэй тул тэр ухаан алдлаа.
Эмнэлэгт сэрэх нь хачирхалтай санагдана. Бага байхад л шилждэг байсан. Зурагтын өмнө нүдээ анин орондоо нээх. Толгойгоо хөдөлгөх гэвэл тархи нь арзайчихаж. Тэр нүдээ аниад юу болсон байж болох тухай төсөөллөө. Төсөөлөл дунд гэнэтхэн нэгэн үг тас хийн цочоов.

"ЦҮНХЭНД!"
Тэр өндийн дуслаа салгаад бослоо. Хаалгаар гарвал эцэг нь, хажууд нь цүнх.
Тэр цүнхээ нээгээд хаав.
Хаагаад л нээв.
Тэр цүнхээ нээгээд гараа дүрэв.
Дүрээд гаргав.
Тэр цүнхнээсээ гараа гаргаад хаав.
Хаагаад л нээв.
Тэр цүнхээ нээгээд хаав.
Хаагаад чагнав.
Тэр цүнхээ чагнаад хөмсгөө зангидав.
Зангираад л тэнийв.
Тэр цүнхээ нээгээд нүдээ дүрэв.
Дүрээд гаргав.
Тэр цүнхнээсээ нүдээ гаргаад гараа дүрэв.
Дүрээд гаргав.
Тэр цүнхээ хаагаад нээв.
Нээгээд л хаав.
Тэр цүнхээ нээгээд толгойгоо дүрэв.
Дүрээд гаргав.
Тэр цүнхээ хаав.
Хаагаад л нээв.


5
MINUTE
NO
BULLSHIT
duck

ЛХАГВАСҮРЭН Гомбо–Ичин
LKHAGVASUREN Gombo–Ichin









НЯМДУЛАМ Цэдэвсүрэн
NYAMDULAM Tsedevsuren



"ХҮЛЭЭЛТ" БЭСРЭГ КИНО

"WAITING" SHORT FILM

ДАВААЖАРГАЛ Цасчихэр

DAVAAJARGAL Tsaschikher

ГАНЦ МОД ГАЛ БОЛДОГГҮЙ ЮМ.....

ONE LOG CAN'T MAKE FIRE .....








НАРАНДУЛАМ Дэнсээ

NARANDULAM Densee

.....?.....

.....?.....




ЧИНБОЛД Лхагва
CHINBOLD Lkhagva



ХӨХ ШУВУУ УРАН БҮТЭЭЛИЙН НЭГДЭЛ

BLUEBIRD CONTEMPORARY– ART CLIQUE













ОРЧИН ҮЕИЙН УРЛАГ – МОНГОЛЫН НИЙГМИЙН ТОЛЬ

Пост–социалист Монгол Улсын иргэд үг хэлэх, үйлдлээ сонгох эрх чөлөөгөө олж аваад гучин жилийн нүүр үзэж байна. Хурдтай шинэчлэгдэж буй нийгмийн өөрчлөлтийг Монголын өнөөгийн үеийн урлаг соргогоор мэдэрч, оюун ухааны хөгжил дэвшлийн манлайлагч үүргээ хөрөнгө мөнгө нь дутагдаагүй бол улам сайн биелүүлэн тусгаж чадах юм. Санхүүжилт бага ч, орчин үеийн урлаг нийгмийн хөгжлийн асуудлыг содоор илэрхийлсээр байна.

Гэтэл яагаад хувь хүн, төр засаг нь хэдэн хүмүүсийн толгойдоо хайрцаг углаад гүйх, эсвэл айраг өөр дээрээ асгах зэрэг хачирхалтай авирыг сайтар харж, сонсож, ойлгох ёстой билээ?

Энэ нийтлэлээр “Өртөө” арт кэмп төсөлд оролцсон дөчөөд уран бүтээлчийн бүтээлийг ажиглан харж, эргэцүүлэн бодож хийсэн дүгнэлтээ хуваалцахыг зорьлоо. Улаанбаатар хотын ойролцоо Хөшигийн Хөндий хэмээх нутагт (Mongolian Artists Residency Studios–д) болон нийслэлийн урлагийн орон зайнд (Хаан Галерей, Улаанбаатар Чуулга, Blackbox The–atre–т) тавигдсан бүтээлүүд Монголын нийгэмд нүүрлэж буй олон сорилтоос: авлига, соёлын өв ба байгалийн хамгаалал, феминизм, ухамсарлал зэрэг таван сэдэвт анхаарлаа хандуулан урлагийн бүтээлээр өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн гэж болно.

“Өртөө” арт кэмпэд бий болсон уран бүтээлүүд нь хөгжиж буй ардчилсан нийгэмд аж төрөх хүмүүст тулгарсан цаг үеийн асуудлуудын талаар тэдний сэтгэл санаа, үзэл бодлыг толь шиг тусган харуулах мэт. Орчин үеийн урлагийн бодит жишээ болох эдгээр бүтээлүүд нь яагаад нийгмийн ухамсрыг дээшлүүлэх, эрүүл иргэний нийгмийг хөгжүүлэхэд чухал хувь нэмэртэй болох тухай энэ нийтлэлд бичлээ.

Арт Кэмпэд толилуулсан концепциудыг илэрхийлэхээсээ өмнө Монголд орчин үеийн урлаг хэзээ, яаж хөгжиж эхэлсэн тухай товч дурдах нь зүйтэй болов уу. 1990 оны Ардчилсан хувьсгалаас өмнө, урлагт социалист реализм ноёрхон, төрөөс урлагт хатуу хяналт, хязгаар тогтоож байсан нь Монголд модерн, постмодерн урлагийг барууны орнуудынх шиг шат дараалан хөгжихөд боломж олгоогүйтэй холбоотой. Социализмын эцэс үеэс төр засгийн хатуу хяналт суларч, уран бүтээлчид чөлөөтэй туурвих орчин бүрдэж эхэлсэн.

Орчин үеийн урлагийн нийгэмлэгийг үндэслэгч, уран бүтээлч Ё.Далх–Очир нийтлэлдээ Монголд болон Зүүн Европд боловсрол эзэмшсэн хэсэг яруу найрагч, уран бүтээлчид анх 1980–аад оны сүүлээр модерн урлагийн “Ногоон Морь” нийгэмлэгийг санаачлан үүсгэн байгуулсныг тэмдэглэжээ.

Улмаар “Ногоон Морь” нийгэмлэг Монголд анхны модерн урлагийн сургууль байгуулж, төдөлгүй төгсөгчид нь болон нийгэмлэгийн бусад гишүүд, уран бүтээлээ олон улсад толилуулж эхэлжээ. 1992 онд гадаадын найз нөхөд, уран бүтээлчдийн тусламж дэмжлэгтэйгээр концепцийн, үйл хөдлөлийн, хээр газрын урлагийн төрлийн төслүүд эхлүүлсэн нь эдүгээ “Арт Кэмп” ба “Лэнд Арт” гэж нэрлэгдэх болжээ.

Авлига

“Өртөө” арт кэмпийн тодорхой хэдэн уран бүтээлүүд Монголын хөгжил дэвшлийг хамгийн их хойш нь татаж буй авлигын асуудлыг тодоор толилуулжээ. Л.Гаваагийн Гарчиггүй концептуал бүтээл нь уран бүтээлч тохиолдлын газар босгосон овоог машинаараа тойрон давхиж, шороон дээр зогсолтгүй, давтан тойрч, үүссэн тоосонд нь төдөлгүй зам ч харагдахаа больж, зорчигчийн толгой эргэн, дотор нь эвгүйрнэ. Уран бүтээлч өнгөрсөн зун болсон УИХ–ын сонгуулийн тухай сэтгэгдлээ илэрхийлж, шудрагаар өрсөлдсөн нэр дэвшигчид, тэднийг дэмжигсэд сонгуулийн үр дүнд хэрхэн харамсаж буйг илэрхийлжээ.

Ганц сонгуулиар ч биш, бусад үйлдлээрээ, улс төрчид ба цөөн тооны эрх баригчид нь хуулиа хувийн сонирхолдоо нийцүүлэн өөрчилж, тал шигээ их баялагтай, баян түүхтэй, хязгааргүй их боломжтой ард түмнээ мөлжиж буй нь Монголчуудын дотрыг муухайруулж, эдийн болон ёс суртахууны доройтлын тойрогт оруулсныг харуулахыг зорьжээ.

Ж.Мөнхжаргалын Үлгэр Биелэх Цагт бэсрэг кино нь хувь хүний орчин цагийн нийгмийн байдалд харамсаж буйг ёжлоно.

Энэ бүтээл сайн үйл хийх нэрийдлээр татварын мөнгийг завшиж, учир утгагүй ажилд зарцуулж буй төрийг шүүмжилжээ. Өнгөрсөн оны эцсээр согтуу жолоочоос хамгаалах нэрээр Сүхбаатарын талбайг тойруулан тус бүр нь 220 кг хүнд, 34 ширхэг шоо чулуу тавьсан тухай бодит байдлыг сануулж иргэд эсэргүүцсэнээр 200 сая төгрөгийн зардлаар байршуулсан эдгээр чулууг зайлуулжээ.

Дэлгэцийн баруун талаас модон хавтангаар дүрсэлсэн энэ чулууг бүлэг хүмүүс арай ядан дааж төв хэсэг рүү зөөж тавина. Хоёр эмэгтэй ерөөл тахил үйлдэн тэдний араас дагана. Үйл явдал өнөөгийн Монголын улс төрчид сонгуулийн сурталчилгааны үеэр үлгэрийн амлалт өгөөд, эрх мэдэлд гарсныхаа дараа яаж амлалтаа биелүүлсэн болж “нүглийн нүдийг гурилаар хуурдгийг” санагдуулна. Ж.Мөнхжаргалын өөр нэг уран бүтээлд бүх тал нь толиор хийгдсэн хайрцгийг толгойдоо углах юм. Эдүгээ Монголчууд бид агуулгаас илүү хэлбэрт, дотор сэтгэлээ биш гаднах үзэмжиндээ онцгой анхаарч буйг шүүмжилжээ.

Бидний энэ дутагдлыг улс төрчид гарамгай ашиглаж сурсан ба урт хугацааны шийдлийг богино хугацааны ашгаар сольж, ард түмнийг хууран мэхлэдэг шинжийг тодоор дүрсэлжээ.

Соёлын Өвийн Хамгаалал

Авлигын нэг шалтгаан нь орчин үеийн ардчилал, нүүдэлчний өв соёлын хоорондын хандлагын зөрчилд оршиж байна. Монголчуудын үндэсний ялгарал болох нүүдэлчний өв соёлоор бол улс төрийн шийдвэрийг, омог, гэр бүл, нутаг усны нарийн харилцаанд суурилуулан гаргадаг уламжлалтай.
Орчин үеийн ардчилсан тогтолцоонд, нүүдэлчний соёл уламжлалаар хандах нь хуулийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг хэрэгжүүлэхэд бэрхшээл үзүүлдэг. Тэгээд алинд нь үнэнч байх тал дээр эргэлзээ, төөрөгдөл үүсгэдэг.
Л.Базарсадын Дугуйгаас Дөрвөлжин рүү бэсрэг кино бүтээлд энэ хэцүү сорилтын нэгэн шинжийг тусгажээ. Эхлээд монгол дээлтэй эмэгтэй хөдөө талд гартаа дэлгэц барин зогсоно. Дэлгэцэн дээр хотын түгжирсэн хөдөлгөөнтэй гудамжны дүрс гарна. Дараа нь зураг солигдож, мөнөөх дээлтэй эмэгтэй хотын хөдөлгөөнт гудамжинд зогсоно. Харин түүний гартаа барьсан дэлгэцэн дээр бэлчиж буй хонин сүрэг харагдана. Энэ бүтээлээр нүүдэлчин өв соёл нь их хотын суурин иргэншлээр хурдтайгаар солигдож буй байдалд ард түмний мэдэрч түгшин, санаа зовсон айдас зовиурыг тусгасан мэт. Гэхдээ Монголын соёл урлагт нүүдэлчний өв соёлын арвин баялаг агуулгууд олон хэлбэрээр тусдаг нь Монголын өв соёл нь ард түмний сэтгэхүй, өдөр тутмын амьдралд гүн бат суурьшсаныг харуулж байгаагийн нэг илэрхийлэл бөгөөд ёс заншил мөхөн үрэгдэх аюулаас айх шаардлагагүй шиг санагдуулна. Жишээлбэл, Б.Чинбатын Нүүдэл–Зүрхний Бичлэг, Ж.Пүрэвсүрэнгийн Дөрвөн Зүгийн Огтолцол, Д.Бадамын Лус, И.Сайнбаяны Амар байна уу? Д.Нарандуламын Уртын Дууны Перформанс 2020, Т.Энхболдын Хөх Сэрэхүй, Ц.Түвшинжаргалын 12.8.2020, Г.Лхагвасүрэнгийн Уялга зэрэг бүтээлүүдээс соёлын өвийн баялаг бүхий чухал үнэ цэнийг харж болно.
Монголын орчин үеийн урлагт өргөнөөр хөндөгдөж буй соёлын өвөө хадгалж, хамгаалахыг уриалсан сэдвүүд нь үзэгчийн сэтгэхүйд эргэцүүлэн бодох,
өв соёлоо хайрлан хүндлэх хүсэл, сэдлийг хөдөлгөж байгаа нь чухал ач холбогдолтой.
Япон зэрэг хөгжингүй, ардчилсан улс орнуудад өв соёлоо хамгаалах нь нийгмийн үнэ цэнийн чухал хэсэг гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрч, хуулиндаа оруулсан байдаг. Харин манай улсад, өв соёлоо яаж хамгаалж, хадгалан үлдээх тухай сайтар бодож боловсруулсан ухаалаг тогтолцоо хараахан бий болоогүй байна. Нүүдэлчний өв соёлоо хадгалах гэж хагас дутуу боловсруулсан оролдлогын уршгаар аливаа шийдвэрийн түвшинд омог, орон нутгийн улс төржилт нь ардчиллын хууль, журмаа эрхэмлэх анхдагч зарчмыг дордуулж, бас авлигыг цэцэглүүлж буй хүчтэй зэвсгийн нэг болон хувираад байна.
Монголын орчин үеийн ардчиллын тогтолцоог хөгжүүлэхэд нүүдэлчин өв соёлоо улс төрийн арга барилаас ялгаж салган, зөв бодлогоор хамгаалах шаардлагатай юм.

Байгалийн Хамгаалал

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2030 Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын дагуу Монгол Улс ногоон эдийн засгийн үзүүлэлтээрээ эхний 30 орны жагсаалтад багтахыг эрмэлзэж байна. Гэтэл эргэн нөхөгдөхгүй байгалийн баялагаа Монголчууд бидэн шиг хурдтай ашиглах аваас, 2030 он гэхэд дэлхийд дөрвөн дэлхий шаардлагатай болно гэж нийтлэлч Т.Болдгэрэл өөрийн нийтлэлдээ анхааруулжээ.
Энэхүү бодит аюул нь онгон байгалиараа бахархаж, байгалиа ээжтэйгээ зүйрлэн шүтэж ирсэн Монголчуудыг хүйтэн усаар цацуулсан мэт цочоон сэрээх цаг болсныг Арт Кэмпэд бүтээсэн олон бүтээл анхааруулаа. Жишээлбэл, Б.Энхтуяагийн Gaia, Ц.Солонгын Солонгон Төөрөгдөл, Б.Бат–Эрдэнэ Баагийн Шингэ, У.Нарбаясгалангийн Restart, Л.Мөнгөнцэцэгийн Өчигдөр зэрэг бүтээлүүд энд багтана. Б.Энхтуяагийн Gaia нь харилцааны, тал газрын урлаг бөгөөд дэлхийн цаг уурын өөрчлөлт, ухамсрын ядуурал, байгальд шингэдэггүй хог хаягдлын асуудлыг хөнджээ.
Таван зуугаад улаан гялгар уут хэвлийн хэлбэрийг дүрслэн талаар нэг тараан байрлуулжээ. Энэ бүтээл нь хэрэглээний нийгмийн хязгааргүй шуналыг шүүмжилж, өнөөгийн Монголчууд хээр хөдөөгөөр явахдаа хэт ихээр харж дассан, хог хаягдлыг сануулна. Хэрэглэсний дараах хогоо зохих газар нь аваачиж хаядаггүй, хайхрамжгүй, хэнэггүй байгаа нь бидний соёл, хүмүүжил ямар болчихоод буйг харуулдаг. Хэрэв Монголчууд бид байгалийн нөөцөө ухдаг эрчээрээ тархи толгойныхоо нөөцөө ухдагсан бол, өнөөдөр хүн амын гуравны нэг нь ядуу, хагас нь модон жорлонтой амьдрахгүй байхсан.
Тийм буйгаас Монгол Улс эдийн засгийн өрсөлдөх чадвараараа дэлхийд сүүлээсээ хоёрт оржээ. Гэтэл ариун цэвэр бол хүний амьдралын, улсын өрсөлдөх чадварын наад захын шаардлага билээ.
Ц.Солонгын Солонгон Төөрөгдөл бүтээлд ширгэсэн голын ёроолоор дэвссэн хар даавуу болон гялгар дэвсгэр нь урсах усанд норж, холоос наранд гялтаганан, гол шиг харагдаж нүд хуурна. Энэхүү бүтээлээр хүний гараар бүтээсэн хиймэл эд зүйлс нь байгалийн цэвэр бүтээгдэхүүнүүдийг хэрхэн орлож, улмаар хордуулан устгаж, жинхэнэ баялаг, хөгжил цэцэглэлийг орлуулан, хүмүүсийг төөрөгдүүлж буйг сануулна.
Гялгар уут, хиймэл эд, хуванцрын өргөн хэрэглээ нь бидний хоол хүнсийг тэжээдэг хөрсөнд шингэн олон арван жилээр хордуулан бохирдуулж буй томоохон гай, уршгийн нэг нь юм. Хүний хэрэглээнээс үүдэлтэй энэ маягийн олон хог хаягдал Монголоос халин дэлхийн байгаль, уур амьсгалд ноцтой аюул учруулж байна. Толгойгоо ажиллуулан байгальд үлдээж буй хар ул мөрөө зөв бодлогоор хянаж хязгаарлахгүй энэ маягаар удаан үргэлжилвэл бид өөрсдөө хог хаягдалтайгаа цуг устах аюул нүүрлээд байна.

CONTEMPORARY ART – MIRROR OF MONGOLIAN SOCIETY

The year 2020 marks thirty years since post socialist Mongolia has availed itself of the benefits from market economy and the freedom of expression of thought. Contemporary art in Mongolia has been a significant representative of the changes that shape our society.
Due to lack of finances, Mongolian contemporary art today is still not at the forefront of the expansion of societal intellect. But why should anyone, let alone the government, care about what a few eccentrics have to say by pouring airag all over themselves or by running around with funny objects on their head? This article aims to present a general assessment of the themes based on some of the artworks created by forty some artists during the "Urtuu" Art Camp project. Five major challenges in Mongolian society are addressed in the artworks viewed on location and at the subsequent exhibitions in Ulaanbaatar: corruption, preservation of cultural heritage, conservation of nature, feminism and awareness.

I would like to propose that the works created in "Art Camp" and the issues they raise, reflect, like a mirror, the current sentiments of the individual as a citizen in a developing democracy. They are, therefore, an essential component of public awareness and education for a healthy civil society.
Before treating the concepts presented in Art Camp, here, it is necessary to give a brief account of how and when contemporary art began in Mongolia.

As evidenced in Socialist Realism, government control over art until the Democratic Revolution did not give any leeway for modern and postmodern art to develop into chronologically distinct movements in Mongolia as freely as it did in the West. It was only towards the end of the Socialist regime that the iron grip of government censorship on art began to loosen. According to an article by founder and artist Yo. Dalkh–Ochir, a group of artists and poets educated in Mongolia and Eastern Europe created the Green Horse Mongolian modern/postmodern art society in the 1980's. In the 1990's, Green Horse opened the first school of post/modern art in the country, and its members and graduates began to present their artworks internationally. In 1992, with the encouragement of foreign artist friends the society launched projects focused on conceptual, performance and land art known as "Art Camp" and "Land Art" projects today.

Corruption

In this year's Art Camp, several works of art responded to the problems of corruption in Mongolia. In the Untitled conceptual performance by L. Gawaa, the audience is a passenger in a car that circles around a small ovoo on a random site in a vast steppe.
The repeated motion created a dirt road that raises so much dust it is impossible for the driver to see clearly or for the passengers to stay comfortable. Gawaa's piece is a commentary on the parliamentary election results in June, a disappointment for those candidates and voters who observed the rules honestly. So, the nauseating cycle of moral and economic poverty in Mongolia continues, an exploitation of a people with opportunities as immense as the steppes of Mongolia by a few individuals in power who rewrite the rules whenever they
want it to suit their own needs.
J. Munkhjargal's artwork also reflects the confusion of the individual facing the current realities of Mongolian society. Fairy Tale Comes True is a video art responding to the irrational expenditures of the government on trivial business.
In December 2019, 34 square blocks of rock weighing around 220 kg each were placed around the Sukhbaatar Square to protect it from drunk drivers, as one official retorted. The stone barriers cost around $40,000 and were later removed. The same rock in Fairy Tale Comes True a video art performance is made of plywood.
A group of men carry the "heavy" rock from the right of the framed shot into the center. Two women follow them with ritual blessing. Munkhjargal's work comments on the promises of fairy tale endings during political campaigns that are glossed over once the candidates are elected into power. It reminds one of a Mongolian popular phrase, "the eye of sin is deceived by flour" meaning, to conceal the truth by making lazy effort in resolving the core problem.
Another performance piece by Munkhjargal is to walk around with a mirrored box covering his head.
It brings the viewer's attention to a cultural blind spot: the widespread tendency to value form over content. This weakness is abundantly exploited by politicians as they demonstratively gratify short–term obligations to the detriment of long–term solutions.

Preservation of Cultural Heritage

One of the root causes of corruption is the national identity crisis over Mongolian nomadic heritage. This dilemma manifests in a confusion of split loyalties to democracy and nomadism, which entails a system of clanship, i.e. political loyalty toward a group based on familial and territorial ties. This approach undermines the government's firmness to implement the Rule of Law.

L. Bazarsad's video art titled From Circle to Square shows a woman in a deel standing in a steppe holding a square screen with a motion picture of a city street.

The scene then switches to show her standing in a street holding a screen with a motion picture of sheep in a steppe. Bazarsad's work echoes the public's concern over rapidly growing urbanization and the loss of the nomadic tradition. Yet the expansive coverage of cultural heritage as a subject in contemporary art indicates that Mongolia's lasting nomadic traditions will not fade away as it is a philosophy deeply rooted in Mongolian identity and lifestyle.

Examples include, B. Chinbat's Nomadism – a Heartbeat, J. Purevsuren's The Crossroads of the Cardinal Directions, D. Badam's Snakes – the Deities of Nature, I. Sainbayan's Amar Baina uu? D. Narandulam's Song Performance 2020, T. Enkhbold's Blue Awakening, Ts. Tuvshinjargal's 12.8.2020, G. Lkhagvasuren's Thread. These works raise awareness of nomadic heritage and incite reflection and desire to protect it. In a prosperous democratic system like that of Japan's, the preservation of cultural heritage is upheld by laws as an inherent value of democracy.

In Mongolia, however, modern democracy is in dire need of separation from nomadic
traditions to protect it from being a method of corruption.

Conservation of Nature

According to the country's plan for the UN Sustainable Development Goals, we are aspiring to be placed among the top 30 countries in the green economy index. But the current rate at which Mongolians are using its nonrenewable resources, we will need 4 planets to sustain our lifestyle by the year 2030. If this fact is not the toughest signal for Mongolia that prides itself on a harmonious relationship with its pristine nature, which we refer to as our mother, then some of the artworks such as B. Enhtuya's Gaia, Ts. Solongo's Rainbow Illusion,
B. Bat-Erdene Baag's Merge, U. Narbayasgalan's Restart, L. Munguntsetseg's Yesterday could help us understand more.

B. Enhtuya's Gaia is an interactive work of land art that speaks to the problems of climate change and the production of unsustainable waste. About half a thousand red plastic bags lay across a steppe making up the outline of a womb. The work critiques capitalism's consumer culture and human greed as the artwork spreads across the landscape like the waste that Mongolians traveling in the countryside have grown too accustomed to seeing.

The question of not being bothered to pick up our waste is indicative of the poor level of manners and common sense. If Mongolians sought to use our own minds as urgently as our natural resources, one third of the population would not be living below the poverty level today, pit latrines would not be a reality for almost half of the population, and Mongolia would not be placing second to last in economic competitiveness.

Ts. Solongo's Rainbow Illusion, in which a stream of black cloth and plastic sheets laying in a dried-up riverbed look like a river from a distance as the wet materials shine and sparkle in the sun. Her work is about the illusion of prosperity that manmade objects and synthetic materials create while they replace organic goods and destroy the real source of precious nonrenewable wealth.

The widespread use of plastic bags and synthetic materials is one of the many environmental hazards contributing to soil contamination. The anthropogenic disturbance causing serious environmental imbalance in Mongolia and in the world is a threat that will destroy us and our plastic if we do not exercise our minds and create systems to manage and reduce our own ecological footprint.

Байгаль дэлхийгээ эх хүнтэй зүйрлэдэг Монголчуудын соёл, уламжлал орчин үед ч хадгалагдсаар байна. Эмэгтэйчүүд нийгэмд маш чухал үүрэгтэйг Монголчууд бид ерөнхийдөө өргөнөөр хүлээн зөвшөөрч хүндэлдэг. Хүйсийн эрх тэгш байдлыг Үндсэн хуулиндаа тусгайлан “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан.

Арт Кэмпэд нэлээд хэдэн бүтээлүүд эмэгтэй хүний үзэл бодол, нийгэмд эзлэх байр суурийг илэрхийлсэн байна. Мэйрагийн Толь 1–р хэсэг 1, Тусгал 2–р хэсэг холимог техникийн уран зурагт бүсгүй хүн гаднаасаа болон дотроосоо өөрийгөө яаж хардгийг дүрсэлжээ.

Толь 1–р хэсэгт урт гэзэгтэй бүсгүй толинд инээмсэглэж буй тусгалаа харан зогсоход зургийн арын хэсэгт хөвж буй олон нүд, нүүрнүүд түүний хэлбэртэй холбогдон ширтэн харах мэт. Ногоон, шар, үзмэн ягаан өнгөнүүд бүсгүйн биеийг тодруулна. Тусгал 2–р хэсэг–т цэцэг, өвс ногоонууд шар, тод ягаан, торын өнгө давамгайлсан зургийг бүрхэж чөлөөтэй хөвж буй хийсвэр олон нүд, нүүр, гарууд зөрөлдөн урсана.

Мэйрагийн бүтээл нь орчин үеийн соёл, загварын сэтгүүл, нийгмийн сүлжээгээр эмэгтэй хүний ертөнцийн зөвхөн нэгээхэн хэсгийг харуулах болсныг үзэгчдэд сануулж, орчин үеийн нийгэмд охидод үлгэр дууриал болохуйц эмэгтэй баатруудын дүр төрөл яагаад нэг хэвийн, цөөхөн байдгийг асуух мэт.

Охидыг багаас нь гэрийн эзэгтэй, эх хүний үүрэгт нийгмээс дасган төлөвшүүлсээр ирсэн. С.Хулангийн Айл Гэр үзэл санааны үзүүлбэрт Монголд өрх толгойлсон ээжүүд олноор олширч буйг онцолж, айл гэр болж тоглож байсан хүүхдүүд том болохоор эрэгтэй хүүхдэд тоглоомоороо үлдэж, эмэгтэй хүүхдэд амьдрал нь болдгийг харуулна. Ц.Нямдуламын Хүлээлт, үзэл санааны үзүүлбэрт уран бүтээлч утасныхаа дэргэд суугаад, хэн нэгнийг залгахыг хүлээнэ.

Харин солигдох өмсгөлөөр нь цаг хугацаа урсаж буйг үзэгч ойлгоно.

Нийгэмд эмэгтэй хүнийг хүлцэнгүй, дуулгавартай, тэвчээртэй байхыг хар багаас нь төлөвшүүлдэг нь эмэгтэй хүнийг нийгмийн амьдралын идэвх султай болгодгийг шүүмжлэх мэт.

Өнөөдөр хувийн болон төрийн хэвшилд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо удаан өсөж байгаа нь гэр бүл, ажил хөдөлмөрт хандах хандлага нь хүйсээрээ ялгаатайг тооцоолдоггүйтэй холбоотой.

Эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд эрх тэгш оролцох нь эрүүл иргэний нийгмийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Хүн амын хагас нь гэр бүл, ажил хөдөлмөрт зарцуулах цаг, хүч, мөн харах өнцөг нь нөгөө хагасаасаа эрс ялгаатай.

Н.Сүндэрьяа Далавчаа Хумисан Эмэгтэй, Далавчаа Дэлгэсэн Эмэгтэй, үзэл санааны үзүүлбэрт хэрэв чухал шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн үзэл бодлыг эрх тэгш тусгадаг болчих юм бол дэлхий яаж өөрчлөгдөх байсан тухай мэдрэмжийг өгөх мэт.

Өнгөрсөн 8–р сард, Монголд 10,000 ээжийг Алдарт Эхийн одонгоор шагнав. Төр засгаас олон хүүхэд төрүүлж өсгөсөн ээжийг шагнаж урамшуулж байгаа нь сайхан хэрэг. Гэвч үр хүүхдээ өсгөж бойжуулахаас гадна, эмэгтэйчүүд нийгэмд олон чухал үүрэг гүйцэтгэдэг.

Чанартай боловсрол, эмнэлгийн үйлчилгээг олгоход төрөөс илүү сайн анхаардаг бол хүүхдээ өсгөх, аюулгүй, таатай орчин бүрдэж, илүү ашиг тустай байхсан. Жишээ нь Исландад, шинэ аавуудад
гурван сарын цалинтай чөлөө олгодог.

Хувийн хэвшлийн байгууллагуудыг дотооддоо хүйсийн эрх тэгш нөхцлийг бүрдүүлсэн соёлоор нь харьцуулж төрөөс урамшуулдаг байна. Цэцэрлэгт өдөрт нэг цагаар хүүхдүүдийг хүйсээр нь тусгаарлан багш нар нь хөвгүүдэд энэрэнгүй байх, охидуудад өөртөө итгэлтэй байх занг төлөвшүүлэх хичээл заадаг ажээ.

Иймм төрлийн арга хэмжээ нь Исландыг хүйсийн эрх тэгш байдлын үлгэр жишээ орон болгож байгааг судалгаагаар тогтоожээ.

Монголд багшлах, асран сувилах, эмчлэх зэрэг хүүхдийг өсгөн хүмүүжүүлэхэд асар чухал үүрэг гүйцэтгэдэг, эмэгтэйчүүд давамгайлсан салбаруудад ажиллах орчинг нь сайжруулах, цалинг нь нэмж урамшуулах нь ээжүүдийн энгэрт одон зүүж, 100,000 төгрөгөөр шагнаснаас илүү, бодитой ашиг тус болохсон.

Ухамсарлал

Монголчууд бид төр засаг нь сонгуулиар амалснаа биелүүлж чадаагүйгээ одон тэмдэг, бэлэн мөнгө тараж аргалж байгаа нь ард түмний өдөр тутмын амьдрал дээрээ тулгарч буй асуудлыг нь шийдэхэд туслахгүй байна гэдгийг хүлээн зөвшөөрч ухамсарлах цаг аль хэдийнээ болжээ. Хэрэв эрх баригчид Монголын нийгмийг чанартай үнэ цэнэ, агуулга бүтээхэд нь дэмжихүйц, найдвартай бүтэц, тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэхэд анхаардаг болчихвол гаднах хэлбэр нь өөрөө зөв болоод ирэх юм. Аливаа зүйлийн доторх агуулга нь гаднах хэлбэр, төрхтэйгээ нийцэж байгаа эсэхийг дүгнэхийн тулд тухайн зүйлийг таньж мэдэх, ухамсартаа шингээх чадамж хэрэгтэй.

Арт Кэмпэд бүтээсэн олон бүтээл тийм ухамсрын тухай байсан бөгөөд ухамсарлалыг мэдрүүлж байлаа. Ж.Ариунтуяагийн Blue Meeting бүтээл нь цэнхэр даавуун ханатай эргүүлгэн хонгилоор явсаар тойргийн голд хүрмэгц үзэгчийн өмнө том тольтой тулгарч байв. Үзэгч бидэнд өөртэйгээ нүүр тулан учирч, үнэн сэтгэлээсээ ярих, үзэл бодлоо цэгцлэх боломж олгох мэт. Бүтээлийг хотод авчирч үзэсгэлэнгийн танхимд байрлуулахдаа голд нь тааз хүрсэн том мод, харин цэнхэр даавууг нь цагаан, жижиг болгон өөрчилжээ. Хөдөө өөрийн үзэл бодлоо цэгцэлсэн тэрхүү хором нь хотод ирээд тэр мод шиг шинэ ертөнц болон хувирч, урам зориг бадраасан мэдрэмж болсон мэт.

Г.Энхжаргалын Атман–2 үйлдлийн урлагийн бүтээлд уран бүтээлч өршөөл үйлдэж, бясалган, өөрийгөө сүүгээр/айргаар ариутгана. Р.Чинзоригийн Мэлмий өрөг бүтээл нь далд ухамсар талын цэцэг шиг дэлбээлж хүний болон байгалийн дотоод үзэсгэлэнг сануулан үзэгчийг ухааралд уриалах мэт. Т.Одгариг 3:30AM дуун бичлэгийн өрөг бүтээлд уран бүтээлчийн дотоод ертөнц, бодлын урсгал, тэр бүхнийг ажиглаж буй ухамсарлахыг мэдрүүлж, улмаар үзэгчийн бодлын урсгалын ганцаардмал, хязгааргүй ертөнцөд түр зуур хань болж мэндчилэх мэт. Д. Баярцэцэгийн Арал, видео бүтээлд цаг хугацааны удаан болоод зогсолтгүй урсгалыг мэдрүүлэн зөөлөн урсах голын тусгалд хадны сүүдэр нартай хамт нүүж буйг харуулна.

Б.Уганцацралын Түгжээ, харилцааны бүтээлд айдас гэсэн бичигтэй гялгар, тунгалаг хальсны дотроос эмэгтэй хүн уудам хөх тэнгэрийн дор, тун тавгүй зогсоно. Айдас эрх чөлөөг чөдөрлөж, өсөн хөгжих боломжийг алдуулдгийг сануулна.

Д.Батхолбоогийн Хий өрөг бүтээлд ертөнцийн амьтай, амьгүй бодис хэзээ нэгэн цагт мөн чанартаа эргэн хувирдгийг сануулна. Н.Сүндэрьяагийн Өндөг ба Даль Жигүүр бэсрэг кино, үйлдлийн урлагт дэгдээхэй болтлоо халамж тэвчээр шаарддаг өндгийг чулуун хана руу хага шиднэ. Энэ бол өнөөгийн нийгмийн тогтолцоо залуусын бүтээлч авьяас, чадварыг өсөж, хөгжихөөс нь өмнө устгаж буйг илэрхийлж байна.

М.Мөнх–Эрдэнэнийн Байршил, концептуал үйлдлийн урлагт даяаршсан, цахим ертөнцөд мэдээллийн хэт ачаалалаас үүссэн анхаарал удаан төвлөрч чаддаггүй болоод хүн өөрийгөө хурдан өөрчлөхийг улам бүр шамдуулахад хүргэдгийг илэрхийлнэ.

Эдгээр бүтээлүүд үзэгчийг өөрийн оршихуй болон түүнийгээ хорвоод яаж илэрхийлэхийг ухамсарлан ойлгоход түлхэж байна. Өнөөгийн сорилт, бэрхшээлтэй олон асуудлыг шийдэхийн тулд юуны өмнө асуудлыг бодитой харж, хүлээн зөвшөөрөх, ухамсарлахаас эхэлнэ. Ухамсарлах нь хариуцлагатай зөв үйлдэл хийхийн урьдчилсан нөхцөл юм. Арт Кэмпийн уран бүтээлчдийн хөндсөн сэдвүүд нь Монголын нийгмийн хөгжилд тулгараад буй сорилт, бэрхшээлүүдийг ухамсарлан ойлгоход чухал үүрэг гүйцэтгэж байна. Үзэгчдэд ил тод засаглалтай, ухамсартай иргэний нийгэмтэй, орон нутаг нь бие даасан хөгжилтэй, байгаль, соёлын өвөө цэвэрээр нь хадгалж хамгаалахад анхаардаг, харилцан хүндэлдэг орчинд эрх тэгш боломжийг бүрдүүлдэг, тийм л улс орны иргэн байх хүслийг төрүүлнэ.

Төр засаг нь соёл урлаг, шинжлэх ухааныг дэмжсэн бодлого явуулж, холбогдох институцийг хөгжүүлэн бэхжүүлэх хэрэгтэй байна. Олон улсын түвшний, орчин үеийн, өндөр чанартай урлагийн музей байгуулж, иргэд нь найз нөхөд, төрөл садны хамт урлагаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй солилцож болохуйц боловсон, соёлтой орчин бүрдүүлж чадвал, эрүүл иргэний нийгмийг хөгжүүлэхэд унацтай хөрөнгө оруулалт болох болов уу.

Нью Йорк хотын аялал жуулчлалын орлогын томоохон эх үүсвэр нь MoMA, Guggenheim, Whitney зэрэг орчин үеийн урлагийн музейн үзэгчдээс бүрддэг. Монгол Улс түүхэн барилгуудаа устгалгүйгээр, хүүхдийн тоглоомын талбайг машины зогсоолоор солилгүйгээр тийм урлагийн музей барихад хангалттай газар нутаг, орон зай бий.

Монголчууд бид байгалийн баялагаасаа гадна оюуны баялагаа, авьяас билигээ олборлон сайхан амьдрах хязгааргүй их боломж бий. Бид ирээдүй, хорвоог харах өнцгөө тэлэхэд орчин үеийн урлаг тусална. Эдгээр өөрчлөлт нь орчин үеийн урлагаа ойлгож, үнэлэхээс эхэлнэ.

Жаргалсайхан Ариунаа, Урлаг Судлаач.

Д. Жаргалсайхан. “Монгол Хүн Баялаг Мөн үү?” Jargal Defacto, 2017 оны 10–р сарын 18, https://www.jargaldefacto.com/article/mongol–khun–bayalag–mun–uu.

The Economist. “The Best Place to Be a Woman?” December 20, 2018. 6:10. https://youtu.be/I7fyqpHKARg

Pd. Purevee. “Workplace gender inequality in Mongolia.” Medium.com, March 05, 2018, https://medium.com/@pureveepd/work–place–gender–inequality–in–mongolia–2154b54e134f.

Т. Болдгэрэл. “Эко Мөр Буюу Хоёр Дэлхий Хэрэгтэй Болсон нь.” Jargal Defacto, 2020 оны 8–р сарын 04, https://www.jargaldefacto.com/article/eko–mur–buyuu–khoyor–delkhii–kheregtei–bolson–ni.

Ё. Далх–Очир. “Но гоон Морь ба Модерн Урлаг.” Хөх Нар Монголын Орчин Үеийн Урлагийн Сэтгүүл, no.3 (July/Aug/Sep 2018): 33.

UB Post сонинд 2020 оны 10–р сарын 19нд хэвлэгдэв.

Feminism

The mother figure is a potent symbol of nature in both Mongolian tradition and modern–day culture. Therefore, the significance of women's roles in Mongolian society is commonly acknowledged and well respected for the most part. Gender equality is also reflected in Mongolia's constitution where it states, "Women and men have equal rights in the social, political, cultural, economic life and family relations." Some of the artworks created at Art Camp have touched upon a woman's view and her place in society.

Meira's Mirror Part 1, Reflection Part 2 is a mixed media painting that depicts the way a girl is seen from the out–side and how she sees herself when looking at a mirror. In Mirror Part 1, a girl with long pigtails looks at the reflec–tion of her smile as floating eyes and faces in the back–ground connect to the contours of her figure.

Purple, green and yellow colors are contained within her shape. In Reflection Part 2, flowers and grass scatter across a yellow, peach, magenta background in a compo–sition of abstract free–floating perpendicularly set hands, eyes and faces. This work presents an opportunity to think about how popular culture, fashion magazines and trends in social media can reflect only a partial view of a woman's world, and further inspires the question of why there is not enough diversity in female superheroes for little girls to dream of becoming.

Little girls are socially conditioned to take on the role of a wife and a mother. S. Khulan's Playing House a conceptual performance brings into focus the disproportionate number of single mother households in Mongolia by showing how playing house stays a childhood game for boys whereas for many girls it becomes a reality later in life.

Ts. Nyamdulam's Expectation, a conceptual performance where the artist sits next to a telephone waiting for it to ring, her change of dresses indicating the passage of time, critiques the passive role that women have been tradition–ally conditioned to adopt in society.

Participation of women at decision making levels both in private and public sectors is still slow to pick up due to the omission of gender–based differences in approaches to family and career responsibilities.

Yet women's equal participation in decision–making is vital to developing a healthy civil society. N. Sunderia's Woman with Wings Folded, Woman with Wings Spread, a conceptual performance piece gives a glimpse into how the world would feel like if important decisions reflected women's perspectives equally.

This year in August, 10,000 women were awarded the Or–der of Exceptional Mothers of Mongolia. That the govern–ment is recognizing the heroism of mothers is laudable. However, besides mothering, women fulfill many other important duties in society.

Ensuring a safe and comfortable environment for parents to raise children by providing better quality education, infrastructure and healthcare would help. In Iceland, for example, new fathers are given 3 months of paid leave. Companies are measured and rewarded based on their monitoring and implementation of gender equality require–ments in their business culture.

In kindergartens, boys and girls are separated for an hour a day so teachers can focus on instilling assertiveness in girls and gentleness in boys. Such practices, studies have shown, are helping change Iceland into a nation that embodies gender equality.

In Mongolia, increasing salaries and creating better working conditions for traditionally female–dominated professions such as teaching, nursing and healing, would be more helpful to mothers than a medal and some $50 per child.

Awareness

We need to recognize that ceremoniously handing out medals and cash in lieu of follow through on promises does not alleviate the problems that people have to battle against. If the government focused on providing solid frameworks that are conducive to creating high quality content, then the form would take care of itself. Recognition of the disparity between how things appear and how they are in reality requires awareness. Some of the artworks created at Art Camp suggest what awareness feels like.

J. Ariuntuya's Blue Meeting, is a labyrinth made of blue cloth at the center of which is a mirror that the viewer can see themselves in. The same work when moved to a gallery space has turned into a white cloth with a tree in the middle that replaced the mirror, showing how self-reflection can transform into inspiration.
G. Enkhjargal's Ataman-2 is a video in which the artist performs a ritual of forgiveness by meditating and then cleansing her energy with airag.
R. Chinzorig's The Eye refers to the all-seeing third eye of wisdom. Like a field of flowers, awareness blossoms all over the steppe moving us to see the wisdom within ourselves and the natural world.
T. Odgarig's 3:30AM, an installation and a recorded sound art piece reveals an intimate account of the artist's own thought process and the mind observing itself, which validates the viewer's own perceptions and experiences inside the mind.
D. Bayartsetseg's Island, a video art showing the quiet passage of time as shadows of a rocky hill reflect in a river peacefully moving with the sunlight.
Uugantsatsral's Lock, an art installation presents a woman trapped in a plastic bag labeled "fear" and standing uncomfortably against the clear blue sky. It raises awareness of how our own fear is what keeps us trapped and limits our potential to grow.
D. Batkholboo's Gas, speaks to the impermanence of the elements of life.
N. Sunderia's Egg and Fledgling, a performance art piece in which an egg that requires care and patience to hatch, is broken by throwing it against a concrete wall. The work speaks to how the current social constructs destroy the creative potential of youth before they get a chance to fully develop.
M. Munkh-Erdene's Location, a conceptual performance expresses

the disorientation of the individual in a globalized, digital world where information overload and short attention span forces him toward self-actualization.
Viewing works such as these raises awareness of one's existence and the way in which one shows up in the world. Awareness is a prerequisite for taking responsibility and inspired action. The issues addressed in the artworks at Art Camp raise awareness of some of the challenges that lay ahead on Mongolia's road to development.
They prompt the viewer to contemplate on the country's need to focus on transparency, independent rural development, conservation of nature and cultural heritage, providing an environment for equal opportunity and mutual respect.
Solutions to these challenges can be unlocked by first acknowledging and waking up to the urgency of the problems we face.
If the government would include the arts and sciences in its institutional reforms by developing policies to financially support these sectors, to build a contemporary art museum of high quality, where citizens can freely engage with friends and family in an intellectual conversation about the world through art, it would be a practical investment into a healthy civil society.
Museums like MoMA, Guggenheim and Whitney are arguably the largest generators of tourism revenue in New York City.

Mongolia has enough land to construct an international level museum of contemporary art in a new location without having to destroy existing historical architecture nor having to sacrifice playgrounds for parking lots. Mongolians have a limitless opportunity to live better by using the talents and creative skills within our own minds.

We need to change the way we see the world. Contemporary art can help us. We can start by understanding and valuing it a little more.
The "Blue Sun" Contemporary Art Center and the Mongolia Artists' Residency Studios realized the Urtuu Art Camp Project in August 2020. The above works can be viewed during the upcoming exhibition organized by the Mongolian Arts Council at Art Space in Edelweiss Hotel starting from November 6th.

By Ariunaa Jargalsaikhan

References:
D. Jargalsaikhan. "Are Mongolian People the Wealth of the Country?" Jargal Defacto, October 18, 2017, https://www.jargaldefacto.com/article/are-mongolian-people-the-wealth-of-the-country.
The Economist. "The Best Place to Be a Woman?" December 20, 2018. 6:10. https://youtu.be/l7fyqpHKARg
Pd. Purevee. "Workplace gender inequality in Mongolia." Medium.com, March 05, 2018, https://medium.com/@pureveepd/workplace-gender-inequality-in-mongolia-2154b54e134f.
T. Boldgerel. "Эко Мөр Буюу Хоёр Дэлхий Хэрэгтэй Болсон нь." Jargal Defacto, August 04, 2020, https://www.jargaldefacto.com/article/eko-mur-buyuu-khoyor-delkhii-kheregtei-bolson-ni.
Yo. Dalkh-Ochir. "Green Horse and Modern Art." Blue Sun Mongolian Contemporary Art Magazine, no.3 (July/Aug/Sep 2018): 33.

Published in UB Post on October 19, 2020
Ulaanbaatar



Зохион байгуулагч / Organizers

Санхүүжүүлэгч / Sponsors

Дэмжигч/Supporter